



НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот

Ажил хүлээлцэх ажлын хэсэг  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/633 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчийн ажил хүлээлцэх журам”, “Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дүрэм”-ийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга Б.Батбаяр нь ажлаас чөлөөлөгдөх болсонтой холбогдуулан албан ажлыг хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Ц.Цэрэндулам (Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч)

Гишүүд:

Н.Золжаргал (Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн ахлах, хүний нөөцийн мэргэжилтэн)

Ж.Сувданзаяа (Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн ахлах, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)

Д.Батбаяр (Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн нярав)

Нарийн бичгийн дарга:

Б.Оюунтунгалаг (Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн архивын ажилтан)

2. Ажил хүлээлцэх ажлыг зохих журмын дагуу шуурхай зохион байгуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Ц.Цэрэндулам)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ч.САЙХАНБАЯР

D:\НӨХГ\Тушаал 2023\А тушаал.docx

115050000035